



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 78

Улаанбаатар хот

### Шийдвэр хүчингүйд тооцох, хөрөнгө хүлээн авах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 4, 8 дахь хэсэг, 9<sup>1</sup> дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 32 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 9 дэх заалт, 62 дугаар зүйлийн 2, 3 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.1, 84.4.3 дэх заалт, Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд 2003 онд байгуулсан Монгол-Оросын “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн үйл ажиллагааны тухай хэлэлцээр, Засгийн газрын 2019 оны 102 дугаар тогтоолоор баталсан “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 5.2 дахь заалт, Засгийн 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Улсын ахлах байцаагчийн 2019 оны ТӨ/18 дугаартай Албан даалгавар, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-т заасан “Үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах” эрх мэдлээ хэтрүүлж, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр, хууль зөрчиж Эрдэнэт үйлдвэрийн хөрөнгөөр бий болсон 64.8 тэрбум төгрөгийн өртөгтэй “Эрдэнэт Медикал” эмнэлгийг цогцолбороор нь “Эрдэнэт үйлдвэр” ХХК (хуучин нэрээр)-ийн Ерөнхий захирлын “Хөрөнгө балансаас хасах тухай” 2016 оны А/108 дугаар тушаалаар “Медипас” ХХК-нд шилжүүлсэн шийдвэрийг хүчингүйд тооцсугай.

2.“Медипас” ХХК-нд шилжүүлэн хүлээлгэж өгсөн хөрөнгийг буцаан хүлээн авч, төрийн өмчид буюу “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгөд бүртгэхийг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл), “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэнд тус тус үүрэг болгосугай.

3.“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Хөрөнгийн тооллого хийж, хүлээлцэх, тооцоо нийлэх ажлыг зохион байгуулах;

3.2.Хөрөнгийг “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүүгийн тайланд тусгах;

3.3.Хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, хамгаалах, үүссэн зөрчил дутагдал, хохирлыг арилгах арга хэмжээ авах;

3.4.Эмнэлгийн тусламж, үйлчилгээг тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг хангах.

132007659

4.Орхон аймгийн Засаг даргын 2017 оны А/02 дугаар захирамжаар “Медипас” ХХК-нд ашиглуулахаар олгосон “Эрдэнэт медиал” эмнэлгийн барилга, байгууламжийн цогцолборт хамаарах 3 га талбай бүхий газар эзэмших эрхийг “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын нэр дээр шилжүүлэн баталгаажуулах асуудлыг судлан шийдвэрлэхийг Орхон аймгийн Засаг дарга С.Батжаргалд даалгасугай.

5.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА *Д. Нарангэрэл* Д.НАРАНГЭРЭЛ